



Д.Отгонцэцэг
Гадаад Хэл Судлалын Ханкук Их Сургуулийн Дорно Дахины Хэл
Судлалын Коллеж, Монгол хэлний тэнхимийн багш, профессор

ИНЭЭХ ҮЙЛДЭЛ ЗОХИОЛЫН БААТРЫН ХЭВ ШИНЖИЙГ ИЛЭРХИЙЛЭХ НЬ

(Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы Итгэлтийн инээх үйлдлийн жишээгээр)

Abstract: This article is a continuation of our observational study having commenced since recently paying a specific interest to the types of verbal and non-verbal means of expressing laughter in the contemporary Mongolian language. This time we have selected the Century’s best novel “Tungalag Tamir” (The Crystal Clear Tamir River), wondering what significance can have laughter action in the characteristics of literary hero types.

Proceeding from the observations made with respect to the laughter actions by the rich Itgelt being one of the major heroes of the novel “The Crystal Clear Tamir River” it can be briefly characterized as follows. The laughter action may serve as another means of further characterizing the literary hero’s body, speech, state of mind and inner world reflecting its unique features. Laughter action may be one of the main components of non-verbal means of expressing the subject, literary hero’s sign language. There is every reason to believe that Itgelt’s laughter is one of such major components required to characterize his behaviour and personal attributes, his way of life. Conducting further studies of other characters compared basing on these observations identified focusing on the character Itgelt’s laughter actions can give an interesting picture to observe.

Key words: laughter action, literary hero, literary hero types, character, characterization

Энэхүү өгүүлэл нь орчин цагийн монгол хэлэнд инээх үйлдэл илэрхийлэх үгэн ба үгэн бус арга хэрэглүүрийн хэв шинжийг тусгайлан сонирхож саяхнаас шинээр эхэлж байгаа бидний ажиглалт судалгааны үргэлжлэл¹ болох юм.

Бид энэ удаа инээх үйлдэл нь зохиолын баатруудын хэв шинжит дүрийг илэрхийлэхэд ямар учир холбогдолтой байж болох талаар сонирхон зууны манлай роман “Тунгалаг Тамир”-ыг² сонгож авлаа.

Монгол улсын төрийн соёрхолт, зохиолч Ч.Лодойдамбын амьдрал, намтар, уран бүтээл, туурвилзүйн тойм болон түүний дотор “Тунгалаг Тамир” романы дүр, уран сайхны онцлогийн талаар Н.Банзрагч (1970), С.Равдан (1970), Ө.Тогоо (1970), Г.Жамсранжав (1971; 1988), Д.Цэдэв (1978), Б.Ганбат (1981; 1987; 1997; 1998; 1999), Т.Дүгэрсүрэн (1982; 1989), Ч.Долгорсүрэн (1986), Ц.Мөнх (1989), Д.Сүрьяа (1990), Д.Гармаа (1999), Т.Баясгалан (2000) нарын зэрэг утга зохиол судлаач, шүүмжлэгч, зохиолч, туурвил зүйч нар янз бүрийн талаас нь судлан үзэж, дурсан тэмдэглэсэн байдаг юм байна.³

* This work was supported by the Hankuk University of Foreign Studies Research Fund of 2014.

¹ Д.Отгонцэцэг. Монгол хэлэнд инээх үйлдэл илэрхийлэх нь. - Monggolhak (Mongolian Studies). Journal of The Korean Association for Mongolian Studies. Republic of Korea. Seoul., 2014. 8. Vol. 38. pp. 159-179.

² Ч.Лодойдамба. Тунгалаг Тамир. Нэмж зассан хоёр дахь удаагийн хэвлэл. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар., 1971. Редактор Т.Содномдаржаа. 622 тал. Зохиогч энэ романаа 1967 оны 4 дүгээр сарын 6-нд бичиж төгсгөсөн тухай уул зохиолын төгсгөлд тэмдэглэсэн байдаг бөгөөд эл романы анхны хэвлэл нь 1967 онд хэвлэгдэн гарчээ.

³ Д.Болормаа. Монгол утга зохиолын судлал шүүмжлэлийн ном зүй (1970-2000). Редактор С.Байгалсайхан, Г.Билгүүдэй. Улаанбаатар их сургууль. Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар., 2010. х.312



Утга зохиол судлаач, шүүмжлэгч Г.Жамсранжав бичихдээ “Тунгалаг Тамир” романы нэг зуун гучаад баатар бүрийн зан төрх, хувь заяа өөр өөр билээ” (1971:617) гэсэн байна.

Утга зохиол судлаач, доктор Б.Ганбат “Миний хувьд урьд нь энэ романы дүрүүдээс зүгээр нэг нэр орсон төдийг нь орхин тоолж, 70 орчим дүртэй хэмээн тооцоолж байсан юм. Энэхүү нэгэн сэдэвт зохиолыг бичих үест юу боловч нэрлэн бичсэн хүмүүсийг тооцоолж үзвэл 110 гаруй болов. Яг ийм зарчмаар тооцоолбол “Үүрийн туяа”-д 140 гаруй, “Цаг төрийн үймээн”-д 50 гаруй дүр байна. Харин романы өгүүлэмжид тодорхой байр эзлэн, үйл явдалд идэвхтэй оролцсон, үзэл бодол, зан чанар нь ялгарсан, бидний энгүүн ярьдгаар “амьд хүн мэт” болсон дүр гэвэл “Тунгалаг Тамир” романы Эрдэнэ, Төмөр, Долгор, Бат, Итгэлт, Должин, Солонго, Дулмаа, Галсан, Ням, Сүрэн, Бадарч, Довчин, Гэрэл, Хуяг, Магсаржав, Дорж, Өлзий, Цэнд, Пүрэв, Цамба, Жамбал, Чимэг, Цэцэг, Түгжил, Павлов, Петр, Жаргал, Эрэнчин, Сүхбаатар, Баяр, Дэжид, Жадамбаа, Дамбадорж, Данзан нарын 35 дүр байна” (1998:245) гэжээ.

Эдгээр баатрын зан төрх, хэв шинжит дүрийг тодотгон дүрсэлж байгаа инээх үйлдлийг нь тухайн зохиолоос түүвэрлэн бүртгэж уг романд инээд нь арваас дээш тэмдэглэгдсэн дүрийг сонгож давтамжийн уруудах дараалалд оруулбал Итгэлт (45), Бадарч (20), Төмөр (17), Эрдэнэ (15), Дулмаа (10), Хонгор (10) гэсэн байдалтай байлаа. Тухайн баатрын инээх үйлдэл илрэх хэв шинж буюу инээх хэв маягийг бүртгэж мөн давтамжийн уруудах дараалалд оруулж үзвэл Итгэлт (27), Бадарч (12), Эрдэнэ (7), Төмөр (5), Дулмаа (4), Хонгор (4) гэсэн дүр зураг гарч байна. Эмэгтэйчүүдийн дотроос инээд нь хамгийн олон дурдагдсан дүр бол Дулмаа бөгөөд тэрээр “хөгжүүн ааштай, ухаалаг, хэрэгтэй цагт зоригтой, үзэсгэлэн төгс, хөгжүүн хөөрхөн ааш, нөхөрсөг, сайхан чанар” (Б.Ганбат 1998:258) бүхий нийтлэг дүр билээ. Инээдний тоо болон инээх хэв маягаараа Дулмаа, Хонгор хоёр адилхан (10:10; 4:4) бүртгэгдсэн⁴ бөгөөд Хонгор үеийн залуучууд дотроосоо инээдээрээ түлхүү илэрсэн нь мөн л түүний зан төлөв, дүрийнх нь өвөрмөц онцлогтой холбоотой байж болох юм. Ерөнхийдөө Бадарч, Төмөр, Эрдэнэ нарын инээх үйлдэл ойролцоодуу (20:17:15) дурдагдсанаас Төмөр, Эрдэнэ нарынх бүр ойролцоо (17:15) байгаа нь сонирхолтой юм. “Эр зоригтой, өрөвч нинжин, цагаан цайлган сэтгэлтэй, тусархуу бөгөөд номхон дөлгөөн зантай, баатарлаг эр Төмөр” (Б.Ганбат 1998:257), хувьсгалч Эрдэнэ нар төрсөн ах дүү нар билээ. Бадарч инээх үйлдлээрээ Төмөрөөс ялигүй илүү (20:17), харин инээх хэв маягаараа Төмөрөөс 2 дахин олон (12:5) бол Эрдэнээс үл мэдэг илүү (12:7) байна. Хэрэв уран зохиолын онолын хуучин ойлголтоор Итгэлт, Бадарч нарыг эсрэг дүр⁵ гэж үзвэл инээх үйлдлийн тоогоороо ч (65:51), инээх хэв маягаараа ч (39:20) үлдсэн, эерэг дүрийнхнээсээ нийлбэрээрээ илүүтэй байгаа нь ажиглагдлаа. Уран сайхны тодорхой нэг бүтээл дэх дүрүүдийн инээх үйлдлийн санамсаргүй тоон үзүүлэлтээс бид ямар нэгэн дүгнэлт хийхийг юуны өмнө урьдал болгоогүй тул үүгээр товчилж Итгэлтийн инээх үйлдлийг тусгайлан сонирхож зарим нэг ажиглалт хийх зорилго тавьсан болно.

Ер нь инээд дотроо олон төрөл зүйл байдаг. Тухайлбал, инээдтэй ямар нэгэн зүйлийг хараад хөгжин инээх, хүнийг санамсаргүй буруу үйлдэл хийснийх нь төлөө шоолон инээх, хэн нэгнийг үзэн ядсан сэтгэлээ илэрхийлж бах таваа хангаж, тавлан инээх гэх мэтээр хүмүүс инээдийг янз бүрийн хэлбэрээр нийгмийн харилцаанд ашигладаг гэсэн үг юм. Мөн ямар ч шалтгаангүйгээр инээхийг бүдүүлэг хэмээн үздэг. Инээхэд учир бий гэсэн үг байдаг. Тийм ч учраас монголчууд “Уйлсныг бүү асуу, инээснийг асуу” гэдэг билээ.

“Тунгалаг тамир” романд тод гарсан өвөрмөц дүрүүдийн нэг нь Итгэлтийн дүр юм. Хэрэв Д.Нацагдорж Дагдан (“Цагаан сар ба хар нулимс”), Ц.Дамдинсүрэн Баян Болд (“Гологдсон хүүхэн”), Б.Ринчен Лодой баян (“Үүрийн туяа”) зэрэг харгис хатуу, хариг харамч, хүнийг өрөвдөх, хайрлах, дэмжих, туслах сэтгэлгүй, дарлан мөрдөгч баячуудын дүрийг бүтээсэн бол Ч.Лодойдамба урьд өмнө дүрслэгдээгүй, хүнийг зарцлах, хөрөнгөжиж баяжихын арга эвийг сайн олсон ямар ч нөхцөлд хэнтэй ч зохицож чаддаг, овжин ухаалаг маягийн баян хүний хэв шинжит дүрийг Итгэлтээр гаргасан байна” (Ц.Мөнх 1989:279).

“Зохиолч Ч.Лодойдамба гуай Итгэлтийн үзэл бодлын ертөнцийг харуулахдаа хүмүүстэй түүний харьцаж байгаа байдал, дотроо хүүрнэн өөртэйгөө ярилцах, бусад хүмүүсийн санал бодлын хэлбэрээр зохиолын янз бүрийн бүлэг хэсгүүдэд 100 гаруй удаа гаргасан аж” (С.Нямзагд 1991:7) гэсэн тооцоо

⁴ “Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн яриа ялгаатайн адил инээд бас ялгаатай. Юуны өмнө эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол илүү их инээнэ. Хоёр хүйснийхэн цугласан үед эмэгтэйчүүд эрчүүдээс 1.5 дахин их инээдэг ажээ. Тэгэхдээ эрчүүд нь голдуу инээх шалтгаан болдог байна”. www.news.mn

⁵ Уран зохиолын сүүлийн үеийн онолоор эерэг ба эсрэг дүр хэмээх ойлголт нэлээд өөр утга, агуулгатай болсон байна. “...”Тунгалаг Тамир”-ын баян Итгэлт (бусдыг мөлждөг), Бадарч (хуучин засгийн тахар), Павлов (цагаантан), Түгжил, Цамба, Жамбал (лам, хулгайч, хоёр нүүртэн) гэдгээр нь эсрэг дүр гэж үзээд Эрдэнэ (ноёнтойгоо заргалдсан), Төмөр (баячуудын адуу малыг хөөдөг), Хуяг (цэрэг эр), Буян чавганц (ядуу буурай хүн боловч Итгэлт, Эрдэнэ нарт уурлаж чадсан), Ням өвгөн (барлаг зарц), Гэрэл (дурласан хүндээ авааль нөхрийнхөө чухал нууцыг олж өгөхөд тусалсан) гэдгээр эерэг дүр гэж үзэх нь урлагийн хууль зүйд харш юм” (Д.Галбаатар 2012:527а). “Ер нь “Итгэлт эсрэг, Эрдэнэ эерэг” гэх юмуу “Баянак цэргийн оргодол, эцэг нь намын дарга” учраас эерэг, эсрэг дүр болно хэмээн үзэх нь урлаг дахь дүрийг загварчилж байгаа бүдүүлэг хандлага мөн” (Д.Галбаатар 2012:538а).

бий⁶.

“Тунгалаг Тамир” романд зохиолын нэг гол дүр болох баян Итгэлт ийнхүү 100 гаруй удаа дурдагдан дүрслэгдсэний 45 удаа буюу бараг тал хувьд нь түүний инээх үйлдэл ямар нэг байдлаар тодорхой тэмдэглэжээ.

Эдгээр 45 удаагийн инээд нь 27 хэв шинжээр ялгарсан байна. Энэхүү 27 хэв шинжийн инээдийг хоёр ба түүнээс дээш удаа илэрснээр нь давтамжийн уруудах дараалалд оруулбал дараах байдалтай болох юм. Үүнд:

- **хөгжилтэй инээх - 7**

(1) Бид хоёроос жаал юм идье гэж бодож байна уу? хэмээн Итгэлт хөгжилтэй инээв.

Энэхүү “хөгжилтэй” инээх үйлдэл нь Итгэлтийн инээх үйлдлийн дотор хамгийн өндөр давтамжтай байгаа бөгөөд бусад хүний хувьд Төмөр (4), Эрдэнэ (3), Хонгор (2), Дулмаа (1), Бадарч (1) гэсэн байдалтай байна. Тайлбар толь бичгүүдэд энэ үгийг “хөгжил баясал ихтэй, баясал цэнгэлтэй” (Л.Болд 2008: 25976), “баясал цэнгэлтэй, хөөр хөгжөөнтэй, наргиан наадамтай” (И.Дамбажав 2010:II693), “хөгжил бүхий, баясал цэнгэлтэй” (Я.Цэвэл 2013:967а) гэх мэтээр тодорхойлсонтой харьцуулбал зохиолын баатруудын сэтгэлийн баясал цэнгэл, хөөр хөгжөөнтэй байдлыг илүүтэй нарийн илэрхийлэхэд энэ хэв маягийн инээх үйлдэл дагалддаг нь тодорхой байна. Энэ төрлийн инээдтэй холбогдуулан дэлгэрүүлэхэд “Инээдэнд давуу тал олон бий. Юуны өмнө хүмүүсийг нэгтгэн сэтгэл санаагаа ойлголцоход нь тусална. Хөгжилтэй, хошин шогийг мэдэрдэг хүмүүс өөдрөг, сэтгэл хангалуун явдаг” (Т.Чимэддагва) гэсэн гаргалга нь Итгэлтийн ахуй амьдрал, сэтгэл санааны байдалтай бараг тохирч байна⁷.

Ер нь “Инээх нь нийгмийн харилцаанд хүмүүсийг нэгтгэж, ойлголцуулдаг ач холбогдолтой. Инээх нь халдварлах шинжтэй учраас хүмүүсийн хооронд эерэг холбоог үүсгэдэг” (Э.Намуундарь 2010:270), “Шведийн эрдэмтдийн явуулсан өөр нэгэн судалгаагаар инээмсэглэл нь бусдад маш амархан халдварладаг... Инээмсэглэл дүүрэн нэгний өөдөөс тэнэг л биш бол ямар ч хүн хариу инээмсэглэхгүй өнгөрч чаддаггүй...” (www.playskull.mn) учраас “Баян Итгэлт ... нь юмны эвийг айхтар олдог, ухаантай, зальтай эр билээ... Итгэлт юухан дээр боловч хашир хянамгай хандаж, ухаан сийлж явдаг овжин бөгөөд зальтай хүн... Гэвч Итгэлт шинэ засагт үнэн голоосоо талархсандаа, түүнийг ойлгосондоо биш, Эрдэнэтэй эвлэрье гэсэндээ биш ерөөс ямар ч засгийн үед, хэнтэй ч зохицон хувирч явах тийм арга ухаантай хүн учраас тэгж байгаа хэрэг билээ...” (Б.Ганбат 1998:248-250).

- **нарийхан дуугаар инээх - 4**

(2) - Жан мин-гийн лимбэ шиг хоолойтой хvн юм гэж Чулууныг хэлэхэд Итгэлт Жан мин гэж юу байдгийг огт сонсоогүй боловч “яг тийм шүү. Та ёстой нэг онож хэллээ” гээд нарийхан дуугаар инээв.

Энэ инээд Итгэлтээс өөр хүнд ажиглагдсангүй. Зохиолд Итгэлтийг тийм ч нарийн дуутай хүн гэж дүрслээгүй. Холбогдох жишээ бүхий ярианы орчноос нь магадлан үзвэл Итгэлт хүнээс тоглоом шоглоомоор юм асууж шалгаасан, өөрөө мэдэхгүй мөртлөө бусдыг худлаа аялдан дагалдсан, өөрийг нь жаахан буруутгах өнгө аяс цухалзсан зэрэг тохиолдолд “нарийхан дуугаар” инээсэн нь тэрбээр харилцааны тухайн байдлаас өөртөө эвтэйхнээр гарахын тулд зориуд хоолойгоо нарийсган инээдэг байж болох талтай юм. Энэ нь үндсэндээ зальтай шинжийн нэг илрэл гэж хэлж болмоор бөгөөд ажиглалтаас үзвэл, нарийхан дуугаар инээх, жингэнэсэн дуугаар инээх, шингэн дуугаар инээд алдах, шингэн хоолойгоор дуу алдах⁸ зэрэг үйлдэл нь үүнтэй ойролцоодуу хэв маягтай хэмээн ойлгогдож байна. Иймд “... Итгэлт бол аль ч нийгмийн ямар ч үед, тэмцэл тулалдааны ямар ч эгзэгтэй ширүүн цагт байдлыг нарийн ажиглаж, амиа аргалж аятайхан амьдарч чаддаг, юмны эвийг олох авхаалжтай овжин хүний дүр мөн” (Г.Жамсранжав 1971:618) гэсэн дүрийн тодорхойлолт нь эдгээр хэв маягийн инээдээр давхар баталгаажиг байна гэж үзэх үндэслэлтэй хэмээн бодож байна.

- **худал инээх - 3**

(3) Итгэлт байн байн худал инээж “за би ч яахав амласнаа өгч болно. Харин цааш нь горьгүй шүү”

6 Б.Ганбат. Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба (амьдрал, уран бүтээл). (Улаанбаатар., 1998. х.318) гэсэн бүтээлийн х.251-252 энэхүү эшлэлийг дам авав.

7 “Эрэгтэй хүмүүсийн хувьд сэтгэл гутралгүй хүмүүс хэвийн эрэгтэй хүмүүсээс 28%-иар илүү, хэвийн хүмүүс хөнгөн сэтгэл гутралтай хүмүүсээс 11%-иар илүү хошигнох чадвартай байна...Үүнээс хошигнох чадвар өндөртэй хүмүүс сэтгэл гутралд бага өртдөг болох нь харагдаж байна. ...Эрэгтэй хүмүүсийн хувьд стрессгүй хүмүүс бага зэрэг стрессстэй хүмүүсээс 15%-иар, дунд зэрэг стрессстэй хүмүүсээс 12%-иар, гүнзгий стрессстэй хүмүүсээс 24%-иар өндөр хошигнох чадвартай байна...Үүнээс үзэхэд хэдийгээр бага зэрэг стрессстэй болон дунд зэрэг стрессстэй хүмүүсийн хошигнох чадвар төдийлөн ялгаагүй боловч ерөнхийдөө хошигнох чадвар өндөртэй хүмүүс стрессст өртөх магадлал бага байна” (Э.Намуундарь 2010: 267-268).

8 Энэ хэв маягийн инээдтэй холбогдуулан дараах жишээг эш татаж болох юм. Үүнд: “Гэвч энэ бол Н.Энхбаярын хувьд МАХН шинэ Засгийн газарт үлдэж болох, живэхийн даваан дээр амь аврах сүүлчийн мөчир нь билээ. Тиймээс ичгүүр сонжуураа алдаад ч атугай зуурахаас өөр замгүй. Тэгээд ч шавар шавхайд нь Н.Энхбаяр биш Н.Алтанхуяг хутгалдсан юм чинь. Харин ч Н.Энхбаяр “дипломат” зан гаргаж “Яанаа, би танай намынхныг эвгүй байдалд оруулья гэж боддоггүй шүү” хэмээн гэнэн царайлж шингэн хоолойгоор дуу алдчихаад нисчихсэн. Гүйцээ!” (Д.Мөнхмаа 2014).



гэж явлаа.

Зохиолд Итгэлт 3 удаа, Бадарч нэг удаа худал инээсэн нь ойролцоо хэв шинжийн баатруудад л тэмдэглэгдсэн хэрэг бөгөөд Эрдэнэ, Төмөр, Бат, Хонгор, Долгор, Дулмаа нарын зэрэг бусад баатрууд ер худал инээсэнгүй. Эндээс үзвэл зохиолын зарим ойролцоодуу хэв шинжийн баатрууд бараг худал инээдэггүйн зэрэгцээ ер нь худал инээх үйлдэл нэлээн хязгаарлагдмал, ховор үйлдэл болох нь ажиглагдаж байна. Энэ нь "Судалгааны энэхүү хэсгээс үзэхэд монгол хүмүүсийн инээх болон инээдийг хүртэх байдал нь өрнөдийн хүмүүсээс ялгаатай байна. Монгол хүмүүс худлаа инээхдээ тааруу, инээхээрээ нүд нь алга болдог онцлогтой" (Э.Намуундарь 2010:270) гэсэн туршилт судалгааны ажлын үр дүнтэй ерөнхийдөө тохирч байгаа хэрэг юм.

- **хүйтэн инээх - 3**

(4) Аав минь сургуульд ийм юм өгч яаж болох вэ дээ. Та тарган үнээний үнээр бодож мөнгийг нь авсан шүү дээ гэлээ. - Чи бид хоёр чинь нэг гэрийн хүн биш билүү гэж Итгэлт хэлээд хүйтэн инээв.

"Хүйтэн инээд" нь "хорсч басамжилсан инээд" (Л.Болд 2008: 11166), "1. Баясах, баярлах хөөрөх сэтгэлийн хөдөлгөөн нүүр царайд тодрох буюу дуу аялгаар илрэх; 2. Басамжлах дооглох сэтгэлийн хөдөлгөөн нүүр царайд тодрох буюу дуу аялгаар илрэх: хүйтнээр инээх; ..." (И.Дамбажав 2010:I.877) учир "Инээмсэглэл нь ихэвчлэн баяр хөөр, аз жаргал, зугаа цэнгэлийг илтгэдэг боловч зарим тохиолдолд түгшүүр, бухимдал, айдас зэргийг ч илэрхийлж болдог. ... Инээмсэглэл бүхэн чин сэтгэлийн байх албагүй байдаг" (Э.Намуундарь 2010:264) гэсэн судалгааны дүгнэлттэй тохирч байна.

- **дотроо инээх - 2**

(5) Түлээ сэрэмжтэй хагалж байхгүй дээ гээд Итгэлт барьсан унагаа чагтлах зуур "дамшиг чинь нуух санаатай" гэж бодон дотроо инээж билээ.

- **жингэнэсэн дуугаар инээх - 2**

(6) Өнөөдөр би Эрдэнийг орлож үзэх үү дээ гээд Итгэлт жингэнэсэн дуугаар инээн, зальтай нүдээр Долгорыг харав.

Итгэлтийн хувьд ийнхүү жингэнэсэн дуугаар инээх нь нарийхан дуугаар инээх хэв шинжийн утга агуулгатай ойролцоодуу гэж үзэж болохоор байна.

Итгэлтийн энэ бүх инээдийн жишээн дээр үндэслэн "инээх" гэдэг үйл үгийн өмнө ямар ямар үг тохиолдож түүний утгыг хэрхэн нэмэн дэлгэрүүлж, яаж чимэн тодотгож улмаар өгүүлбэр зүйн хувьд чухам ямар үүргээр орсныг дараах байдлаар загварчилж болох юм. Үүнд:

1. Инээх гэдэг үйл үгийн өмнө дараах үгс уламжлалт ойлголтоор дүр байдал заасан байц гишүүн буюу сүүлийн үеийн хуваариар үйлийн тодотголын үүргээр тохиолдсон байна. Үүнд:

- хөгжилтэй инээх
- худал инээх
- хүйтэн инээх
- ёжлон инээх
- ёжтой инээх
- жингэнүүлэн инээх
- жоготой инээх
- зальтай инээх
- ихэмсгээр инээх
- маасайн инээх
- маг маг инээх
- тас тас инээх
- ха ха инээх
- хангинуулан инээх
- хүчлэн инээх
- шоолон инээх
- янцаглан инээх

2. Инээх гэдэг үйл үгийн өмнө дараах үгс шууд бус тусагдахууны үүргээр тохиолдсон байна. Үүнд:

- дотроо инээх
- нарийхан дуугаар инээх
- жингэнэсэн дуугаар инээх

3. Инээх гэдэг үйл үгийн өмнө дараах хэллэг тохиолдсон байна. Үүнд:

гижиг нь хүрсэн бололтой инээх
 майлсан ишиг лугаа адил инээх
 нүд ирмэн инээх

Эдгээрийг хэлзүйн бүтцээр нь нарийвчлан үзвэл дараах байдалтай болно. Үүнд:

Нэр үгийн үндэс + тай³ загвараар: (4): хөгжилтэй (хөгжил), ёжтой (ёж), жоготой (жог), зальтай (заль).

(7) Итгэлт хөгжилтэй инээв. Нямыг шахаж дэгсдүүлэн буудуулж байх нь зугаатай хэрэг байлаа.

(8) Дөрвөн жил энэ Далайд идүүлж байгаа хүн дээ гээд Итгэлт өргөн тайван бөгөөд дотуур ёжтой инээв.

(9) Аятайхан согоо байна шүү, дамшиг чинь гээд Итгэлт жоготой бөгөөд гижиг нь хүрсэн бололтой инээв.

Жоготой гэдэг үгийг тользүйчид “жого бүхий, ов мэх, башир бааш, арга заль бий... жоготой инээх - учиртай инээх” (Л.Болд 2008: 916а), “далд учир бүхий, жого бүхий” (Я.Цэвэл 2013:349а) гэж тайлбарласан бол жого хэмээх үгийг судлаачид “ов мэх, башир бааш, арга заль, учир байдал” (Л.Болд 2008: 916а), “учир жиг, хачирхах зүйл” (Ш.Чоймаа нар 2011:309б), “жиг, далд учир начир” (Я.Цэвэл 2013:349а) гэх мэтээр оноосон байна.

(10) Тааж л байг гээд Итгэлт хоолойдоо зальтай инээснээ Ням гуай, Пүрэв тайжийн адуучны сураглаж явсан хоёр тэр байна гэж нөгөө хоёр морийг заав.

Үйл үгийн үндэс + н загвараар: (8): ёжлон, жингэнүүлэн, маасайн, хангинуулан, хүчлэн, шоолон, янцаглан, янцагалан.

(11) - Эх дагина гуай хөлдүү тарган мах оруулж ирээд сайхан бууз хийж өгсөн гэж Нямын хэлэхэд “Таны аз гэдэг ч түмний эх унасан хүүхэд шиг яваа юм байна” гээд Итгэлт толгойгоо хаялан жингэнүүлэн инээж нүднийхээ нулимсыг арчив.

(12) Эхнэртэй хамт нэлээд ууж сүрхий согтсонд эхнэрийн сэтгэл тайтгарснаар барахгүй хөгжин дуу дуулж, Итгэлтийг хошуун дээрээс нь шов хийтэл үнсэв. Итгэлт гайхсан нүдээр эхнэрийг харан маасайн инээв.

(13) Хамжлага нараа морь илжиг мэт зүтгүлэхээ мэдэвч, хар ус өгөхөө мэддэггүй Пүрэв тайж шиг хүн биш. Ууцгаа, идэцгээ, Дулмаа Должин та нар тавгаа сэлбээч, Нямаа гуай дахиад барь» гэж байн байн ярьж, хангинуулан инээж байв.

Угтан чимэх үгээр: (3): маг маг, тас тас, ха ха

(14) Олзонд баярлахгүй хэн байх вэ? Зүрхтэй л дөрийг нь олж байгаад гулгуулаад байдаг хэрэг ээ. Өвгөн минь гэж Итгэлт маг маг инээн хэлжээ.

15 Шушмаа минь хүнээ олсонгүй дээ гэж Итгэлт хэлээд маш баяртай хангалуун тас тас инээв.

(16) Чи энэ чулуу шиг эдээрээ жинс хийгээд зарвал одоо үед хар ялаа шиг олон болж байгаа ван, бэйл, бэйс, гүнгүүд үнэтэй авах байсан даа гээд Итгэлт ха ха хэмээн их л хөгжилтэй инээхэд Эрдэнэ ч инээв.

Хэллэгээр: (3): майлсан ишиг лугаа адил, нүд ирмэн, гижиг нь хүрсэн бололтой

(17) - Нөгөө бүсгүй хүний үс нь урт, ухаан нь богино гэдэг чинь л энэ байхгүй юу даа гээд Итгэлт нүдээ жартайлган хадан дээрээс майлсан ишиг лагуу адил инээв.

(18) - Аятайхан согоо байна шүү, дамшиг чинь гээд Итгэлт жоготой бөгөөд гижиг нь хүрсэн бололтой инээв.

Тэмдэг нэрээр: (2): худал, хүйтэн

(19) Должин энэ саналыг баяртай дэмжиж Итгэлтэд хэлсэн. Гэтэл нөхөр нь хүйтэн инээж «Бадарч миний хөрөнгөнөөс долоох азгүй байх аа» гэжээ.

Орон цагийн нэрээр: (1): дотроо

(20) - Задарсан дамшиг, билчээрт азарга уургалдаг байх нь ээ гэж Итгэлт дотроо инээн хэлэхэд түүний үгэнд зэмлэх өнгө огт байсангви.

Тэмдэг нэр + дуугаар: (3): жингэнэсэн дуугаар, нарийхан дуугаар, царгиа дуугаар.

(21) Хүүхдүүд өсөөд Должин бид хоёр хөгширч л байна гээд Итгэлт хөгжилтэй бөгөөд жингэнэсэн нарийхан дуугаар инээв.



(22) - Орос оо чамд намайг согтоох архи байна уу? гээд Итгэлт царгил нарийхан дуугаар инээхэд Павлов дурамжхан инээмсэглэв.

Тэмдэг нэр + аар⁴ (1): ихэмсгээр

(23) Итгэлт ихэмсгээр инээв. Гэвч энэ инээдэм нь Нямааг зэмлэсэн Бадарчийг дэмжиж талархсан тэмдгийн аль нь ч байсангүй.

Итгэлтийн инээх хэв маягийн дотор “хөх инээд” нэлээн сонирхолтой дүрслэгдсэн байдаг бөгөөд эл байдлыг сонирхон үзэхийн өмнө монгол хэлний тайлбар толь бичгүүдэд энэ хөх инээдийг хэрхэн тайлбарласныг ажиглая. Энэхүү **хөх инээд (нь) хүрэх** гэдэг хэллэгийг толь бичигт “а. дургүйлхэн хорссон байдал гаргах, зэвүүцэх; б; басамжлах, тавлах” (Л.Болд 2008: 11166), “а. дургүй нь хүрч, зэвүүцэн инээх; б; хүний мууд бах тав нь ханаж инээх” (И.Дамбажав 2010:1.876), “а. дургүй нь хүрч зэвүүцэн инээх; б; юмны мууд бах тав нь ханаж инээх” (Я.Цэвэл 2013:431а) гэх зэргээр тайлбарласан байна.

“Тунгалаг Тамир” романд Итгэлтийн хөх инээд гурван удаа тэмдэглэжээ. Үүнд:

(24) Итгэлт ширээн дээр байсан лааг үлээгээд эхнэрийн хойноос хөх инээд нь хүрэн алхав.

(25) Ноён Сүрэнгийн хангал морьд өртөөнд гүйх, ноёд тайж нарт албан татварт өгөх мөнгө олох гээд хөлсөө гарган зүтгэж явахыг харна гэж бодоход Итгэлтийн хөх инээд нь хүрч, гижиг нь хүрэх шиг болно.

(26) Итгэлт тэр морийг аваагүй бөгөөд хүн доромжлох гээд ам руугаа алгадуулж үг дуугарч чадахгүй болоод царай нь минчийн хор нь буцлан суусан хүнийг хараад хөх инээд нь хүрч, бэрдээ бахархан байж билээ.

Тайлбар толь бичигт өгөгдсөн тодорхойлолтоор дээрх 3 хөх инээдний утгыг тайлж үзвэл 25, 26 дахь өгүүлбэрийн санаа үндсэндээ дүйж байгаа бол 24 дэх өгүүлбэрийн санаа төдийлөн тохирохгүй байгаа мэт ажээ. Энэ өгүүлбэрийн санааг холбосон орчинд нь магадалбал эл өгүүлбэрийн өмнө нь “Гуйван босож эхнэрийн дэргэд очоод түр зогссоноо хүзүүдэн авч үнсээд харвал ичих айхаа мартсан хоёр бор нүд харцтай нь тулгарав. Итгэлт эхнэрийг шууд өргөтөл “Би өөрөө” гээд Итгэлтийг зайлуулснаа ор луу явлаа” гэсэн өгүүлбэр, хойно нь “Маргааш нь Итгэлт өглөө эрт босож явсан билээ” гэсэн өгүүлбэр байгаа бөгөөд энэ бүгдийг холбон үзвэл Итгэлт юмны мууд биш, харин ерийн бах нь ханаж хөх инээд нь хүрсэн шинжтэй байна.

Энэ бүхний эцэст “Монголын орчин үеийн уран зохиолд бүтээгдсэн 208 романы дүрүүдийг энэ мэтээр тооцоолон харьцуулах боломжгүй нь ойлгомжтой. Дээрхийг өгүүлэхдээ юу боловч “Тунгалаг Тамир” роман нь хамгийн олон уран сайхны дүрийг тод томруун, төгс сайн бүтээж чадсан бүтээл юм. Энэ нь түүний уран сайхны нэг томоохон онцлог, манай орчин үеийн уран зохиолд гарсан тэмдэглүүштэй үзэгдэл гэдгийг хэлэх гэсэн юм” (Б.Ганбат1998:245-246).

ДҮГНЭЛТ

“Тунгалаг Тамир” романы нэг гол баатар болох баян Итгэлтийн инээх үйлдэлд хийсэн энэ мэт ажиглалтаас үүдэн дараах зүйлийг товчхон хэлж болох юм. Үүнд:

- Инээх үйлдэл нь тухайн субъект, зохиолын баатрын бие, хэл, сэтгэлийн байдал болон дотоод ертөнцийнх нь өвөрмөц онцлогийг давхар илэрхийлдэг нэгэн зүйл хэрэглүүр байж болох юм.
- Инээх үйлдэл нь тухайн субъект, зохиолын баатрын дохионы хэлийг илэрхийлэх үгэн бус хэрэглүүрийн нэг гол бүрэлдүүлбэр байж болно.
- Итгэлтийн инээх үйлдэл нь түүний зан төрх, хувийн араншин, ахуй амьдралынх нь байдлыг илэрхийлэхэд зайлшгүй хэрэгтэй тийм бүрэлдүүлбэрүүдийн нэг нь мөн байна гэж үзэх үндэстэй байна.
- Итгэлтийн дүрийг инээх үйлдлээр нь баримжаалан тодорхойлсон энэхүү ажиглалтад үндэслэн цаашид бусад дүрийн шинжлэлийг энэ мэтээр харьцуулан үзвэл сонирхолтой дүр зураг ажиглагдаж болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Банзрагч, Н. (1970.8). “Тунгалаг Тамир”-ыг тунгаан бодоход. *Утга зохиол урлаг сонин*. (33).
- Баясгалан, Т. (2000). “Тунгалаг Тамир” романы Итгэлтийн дүрийн эх дүрийн асуудалд. - *“Утга зохиол судлал”*, ШУА, ХЗХ, Том 7 (XXIV), fasc 16, (153-165).
- Болд, Л. (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. 5 боть*. Улаанбаатар. Бемби сан. XXXX-+3278+IX
- Болормаа, Д. (2010). *Монгол утга зохиолын судлал шүүмжлэлийн ном зүй* (1970-2000).

- Байгалсайхан, С., Билгүүдэй, Г. *Улаанбаатар их сургууль*. Хэл зохиолын хүрээлэн (312) Улаанбаатар Галбаатар, Д. (2012). *Уран зохиол. Онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь*. (594).
- Ганбат, Б. (1981). *"Тунгалаг Тамир" романы тухай*. Улаанбаатар (82).
- Ганбат, Б. (1987.2.28). Лодойдамбын тухай шинэ ном. *Үнэн сонин*, 51, 5.
- Ганбат, Б. (1997.3). XX зууны гол туурвил. *Утга зохиол сонин*, 7, 2.
- Ганбат, Б. (1998) *Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамбын амьдрал, уран бүтээл*. (317). Улаанбаатар.
- Ганбат, Б. (1998). *Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба (амьдрал, уран бүтээл)*. (318). Улаанбаатар.
- Ганбат, Б. (1999.3.2). Цагийг эзэлж, ард түмний үнэлсэн роман. *Засгийн газрын мэдээ*, 39, 5.
- Гармаа, Д. (1999.6.26-28). Дөрвөлжин бурам шиг сайхан ном. *Үнэн сонин*, 71, 3.
- Дамбажав, И. (2010). *Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж*
- Долгорсүрэн, Ч. (1986). *Лодойдамбын тухай дурсамж* (118). Улаанбаатар.
- Дүгэрсүрэн, Т. (1982). Ч.Лодойдамбын жүжгийн зохиолууд. *Хэл зохиол судлал*, ШУА, ХЗХ, XVII боть, дэвтэр 14 (170-185).
- Дүгэрсүрэн, Т. (1982). *Ч.Лодойдамбын намтар зохиол* (141). Улаанбаатар.
- Дүгэрсүрэн, Т. (1989). Ч.Лодойдамбын намтар уран бүтээл. *Монголын орчин үеийн уран зохиолын түүх II* (268-287).
- Жамсранжав, Г. (1971). Төгсгөлийн үг. Ч.Лодойдамба. *Тунгалаг Тамир* (615-22). Улаанбаатар.
- Жамсранжав, Г. (1988). *Тунгалаг Тамир"-аас үүдсэн бодол*. *Утга зохиолын шүүмжлэл-85* (147-150).
- Мөнх, Ц. (1989). Чадраабалын Лодойдамба. *Монголын орчин үеийн уран зохиолын түүх* (1941-1960). II боть (268-287). Улаанбаатар.
- Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг*. I боть. А- ОЮУТАН. XII+3-1217, II боть. Ө-ЯШИН. VI+3-1239. Улаанбаатар. "Өнгөт хэвлэл" ХХК.
- Намуундарь, Э. (2010). Инээд. *Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл*. МУИС, 13, 263-271.
- Нямзагд, С. (1991). *Итгэлт ба эдийн засгийн сэтгэлгээ*. Улаанбаатар.
- Равдан, С. (1970.8.8). Тунгалаг Тамир. *Үнэн сонин*, 202, 3.
- Сүрьяа, Д. (1990). "Тунгалаг Тамир"-ын баатрууд. *Зохиол бүтсэн намтар* (12-14)
- Тогоо, Ө. (1970.7.8/ 28). "Тунгалаг Тамир"-ын дөрөв. *Утга зохиол урлаг сонин*, 34, 1.
- Цэдэв, Д. (1978). "Тунгалаг Тамир" романы хэв шинжийн асуудалд. *Зохиолчийн урлах эрдэм*. Улаанбаатар.
- Цэвэл, Я. (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар. XXII + 1311
- Чоймаа, Ш., Баярсайхан, М., Батхишиг, С., Мөнх-Учрал, Э. (2011). *Монгол хэлний хадмал толь*. (кирил-монгол-тайлбар). Улаанбаатар, 1138
- Чимэддагва, Т. Аз жаргал инээмсэглэлээс эхэлдэг. www.news.mn
- Мөнхмаа, Д. (2014.11.15). Зөвшилцөх ажлын хэсгийн бүтцийг хар даа, Н.Энхбаярыг хайрлах уу. www.zaluu.com
- Pyurbeev, G.Ts. (2007). Mongolian smiles as nonverbal means of communication. - "Mongolica". An International Annual of Mongol Studies. Vol. 20 (41), 379-387. Улаанбаатар. www.news.mn